

25 ЖИЛ
ЭРХИЙНХЭЭ ТӨЛӨӨ БИЧИЦГЭЭЕ

ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ



ЗАХИДАЛ БИЧИЖ ӨӨРЧЛӨЛТ ХИЙЦГЭЭЕ

2026



ЭРХИЙНХЭЭ ТӨЛӨӨ БИЧИХ НЬ

25 ЖИЛ
ЭРХИЙНХЭЭ ТӨЛӨӨ БИЧИЦГЭЭЕ
ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ

Захидал хэн нэгний амьдралыг өөрчилж чадна. Энэ бол "Эрхийнхээ төлөө бичицгээе" дэлхий даяарх захидал бичих аяны үндсэн санаа юм.

Энэ жил “Эрхийнхээ төлөө бичицгээе” кампанит ажлын 25 жилийн ой тохиож байна. 2001 оноос хойш дэлхийн өнцөг булан бүрд амьдарч буй сая сая хүн бусдын амьдралд бодит өөрчлөлт авчирч чадна гэсэн энгийн атлаа хүчирхэг итгэл үнэмшлээр нэгдсээр иржээ.

Тэд хамтдаа хууль бусаар хоригдсон хүмүүсийг эрх чөлөөгөө эргүүлэн олж авахад нь тусалж, гэр бүлүүдийг дахин нэгтгэж, хүний эрхийг зөрчсөн хууль тогтоомжийг өөрчлөхийг шаардахын зэрэгцээ эрх нь зөрчигдсөн тоо томшгүй олон хүнд тэд мартагдаагүй, ганцаараа биш гэдгийг нь мэдрүүлж чадсан юм.

Өнөөдөр дэлхий даяар дарангуйллын арга барил газар авч, шүүмжлэл, эсэргүүцлийг нухчин дарах, хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах явдал улам бүр нэмэгдэж байна. Хүмүүс үзэл бодлоо тайван замаар илэрхийлснийхээ төлөө хоригдож, хүйсийн баримжаа, бэлгийн чиг баримжаа болон бусад хувийн онцлогоосоо шалтгаалан ялгаварлан гадуурхалт, хавчлагад өртөж байна.

Энэ жилийн кампанит ажлаар онцолж буй найман хүний түүх хэдийгээр өөр өөр боловч тэдний эрх, эрх чөлөө зөрчигдөж байгаа дүр зураг ижил юм. Тэдний эр зориг, тууштай байдал нь шударга бус явдлын эсрэг дуу хоолойгоо нэгтгэн, хамтдаа тэмцэхийн чухлыг бидэнд сануулж байна.

Таны бичсэн захидал, зурсан гарын үсэг, илгээсэн урам зоригийн үг бүр эрх нь зөрчигдсөн хүмүүст итгэл найдвар төрүүлж, тэдний амьдралд бодит өөрчлөлт авчрахад хувь нэмрээ оруулж чадна.

“Эрхийнхээ төлөө бичицгээе” кампанит ажил 25 жилийн турш бид эвлэлдэн нэгдэж, хамтдаа дуу хоолойгоо хүргэснээр хүний амьдралд бодит өөрчлөлт авчирч чаддагийг харуулсаар ирлээ. Одоо бид ч бас өөрчлөлтийн дараагийн түүхийг хамтдаа бүтээцгээе!



ЗАХИДАЛ БИЧИЖ ГАРЫН ҮСГЭЭ ЗУРЖ ТВИТТЕРЭЭР ЖИРГЭЭРЭЙ

«ЭРХИЙНХЭЭ ТӨЛӨӨ БИЧИЦГЭЭЕ» ХЭРХЭН ӨРНӨДӨГ ВЭ?

1. 200 гаруй улс орон, газар нутагт хүмүүс захидал бичих төрөл бүрийн арга хэмжээнд нэгдэж,
2. Сая сая захидал, цахим шуудан бичиж, твиттерээр жиргэж, өргөх бичигт гарын үсгээ зурж,
3. Эрүүдэн шүүгдсэн, үзэл бодлоо илэрхийлснийхээ төлөө хоригдсон, орогнол эрэх эрх нь зөрчигдсөн хүмүүст эв санааны нэгдлээ илэрхийлж,
4. Шийдвэр гаргагчид, эрх баригчид, засгийн газарт шахалт үзүүлж,
5. Эрх нь зөрчигдсөн хүмүүст, тэдний гэр бүлд дэмжиж байгаагаа илэрхийлж,
6. Идэвхтнийг суллаж, шударга ёсыг тогтоож, өөрчлөлтийн төлөөх дуу хоолойг хамгаалдаг.

ЯАГААД БИД ҮЙЛ АЖИЛЛАГАА ӨРНҮҮЛЭХ ХЭРЭГТЭЙ ВЭ?

Улс орнуудад ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх зөрчигдөж, шударга бусын эсрэг дуугарах нь эрсдэлтэй байна. Таны үг, захидал, үйл ажиллагаа эрх баригчдад нөлөөлж, хүний эрхийг хамгаалах, хүний эрх зөрчигчдөд хариуцлага тооцоход тусалдаг.



БИД ХЭНД БИЧИХ ВЭ?

Жил бүр бид хоёр төрлийн захидал бичихийг хүмүүст уриалдаг. Нэг нь өөрчлөлт хийхэд тусалж чадах ерөнхийлөгч, цагдаагийн дарга зэрэг эрх мэдэл бүхий албан тушаалтнуудад захидал уриалга илгээх, нөгөө нь эрх нь зөрчигдсөн хувь хүн, бүлэг хүмүүст эв санааны нэгдлээ илэрхийлж, бид тэднийг мартаагүй гэдгийг сануулж, зоригжуулдаг.



ҮЙЛ АЖИЛЛАГАА ҮР ДҮН АВЧИРДАГ УУ?

Тийм ээ! Жил бүр таны бичсэн захидал, үйл ажиллагааны үр дүнд бодит өөрчлөлт гардаг. Хилсээр хоригдсон хүмүүс суллагдаж, хүний эрх зөрчигчдөд хариуцлага тооцож, хорих газарт хүнлэг нөхцлийг бий болгодог.



“Та бүхэн бидэнд хамгийн их хэрэгтэй байсан тэр мөчид дэмжлэгийн гараа сунгасан. Намайг хоригдож байх хугацаанд ээж минь маш их шаналж, хүү маань ч өвдсөн байсан. Харин энэ кампанит ажил бид бүгдэд хүч тэнхээ, урам зориг өгсөн. Эмнести Интернэшнлд хэчнээн их талархаж байгаагаа үгээр илэрхийлэхийн аргагүй.”

Доргелес Нгессан, Камерун Улс

Камеруны эдийн засгийн нөхцөл байдалд санаа зовниж байсан Доргелес Нгессан 2020 оны есдүгээр сард анх удаа эсэргүүцлийн жагсаалд оролцжээ. Тайван жагсаалын үеэр түүнийг баривчилж, “бослого гаргасан, цуглаан, хурал, жагсаал зохион байгуулсан” гэх хэрэгт буруутган таван жилийн хорих ял оноосон байна. 2022 оны “Эрхийнхээ төлөө бичицгээе” кампанит ажлын хүрээнд дэлхийн өнцөг булан бүрээс түүний төлөө олон мянган захидал илгээсний үр дүнд Доргелес 2025 оны нэгдүгээр сард суллагдаж, гэр бүлийнхэнтэйгээ эргэн уулзжээ.

ЭВ САНААНЫ НЭГДЛЭЭ ИЛЭРХИЙЛЭХ НЬ ЯАГААД ЧУХАЛ ВЭ?

Танихгүй хүнд захидал бичих нь ямар ч өөрчлөлт авчрахгүй гэж та бодож магадгүй. Гэвч эрх чөлөөгөө хасуулсан, амь нас нь аюулд учирсан, эсвэл ойр дотнын хүнийхээ төлөө шударга ёсыг эрэлхийлж буй хүнд таны дэмжлэг асар их хүч өгдөг. Таны илгээсэн захидал, зурвас тэдэнд ганцаараа биш гэдгийг мэдрүүлж, сэтгэлийн дэм, итгэл найдвар төрүүлж чадна.

“Энэ бүхэн бидэнд асар их хүч, урам зориг өгсөн. Маш олон хүн бидэнд захидал илгээж, ‘Бууж өгч болохгүй шүү, охид минь. Төр та нарын эрхийг зөрчсөн бол үүнийхээ төлөө хариуцлага хүлээх ёстой’ хэмээн зоригжуулдаг байлаа. Бид маш олон захидал, бэлэг, чин сэтгэлийн дэмжлэг хүлээн авсан. Бид ганцаараа биш, бидний төлөө хамтдаа тэмцэж буй хүмүүс байдаг гэдгийг мэдрэх үнэхээр сайхан байсан. Биднийг дэмжсэн Эмнести Интернэшнл болон бусад байгууллагад гүнээ талархаж явдаг.”

Дання Браво, “Амазоны төлөөх дайчин эмэгтэйчүүд” хөдөлгөөний гишүүн

2025 оны “Эрхийнхээ төлөө бичицгээе” кампанит ажлын хүрээнд Дання Браво болон “Амазоны төлөөх дайчин эмэгтэйчүүд” (Guerreras por la Amazonía) хөдөлгөөний бусад гишүүн уур амьсгалын шударга ёсны төлөөх тэдний тэмцлийг дэлхий даяарх хүмүүс дэмжиж байгааг мэдэрч, ихээхэн урам зориг авсан юм. Эквадорын хойд Амазоны бүс нутагт амьдардаг охид, залуу эмэгтэйчүүдээс бүрдсэн тус хөдөлгөөн орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, байгаль орчинд ноцтой хор хөнөөл учруулж буй хийн шатаалтыг зогсоохын төлөө тэмцэж байна. Шүүхээс 2021 онд хийн шатаалтыг бүрэн зогсоох шийдвэр гаргасан боловч уг шийдвэр өнөөг хүртэл бүрэн хэрэгжээгүй байна. Кампанит ажлын хүрээнд Дання Европт айлчилж, хөдөлгөөнийхөө үйл ажиллагаа, тулгамдаж буй асуудлыг шийдвэр гаргагчид, Эмнести Интернэшнлийн дэмжигчид болон залуу идэвхтнүүдэд танилцуулжээ. Улмаар 2026 оны дөрөвдүгээр сард Эмнести Интернэшнл тус хөдөлгөөний гишүүдтэй хамтран дэлхийн өнцөг булан бүрээс цуглуулсан гарын үсгийг Эквадорын Байгаль орчин, эрчим хүчний яаманд гардуулсан юм. Үүний дараа тус яам төрийн байгууллагууд болон хийн шатаалтын нөлөөнд өртсөн орон нутгийн иргэдийн төлөөллийг оролцуулсан техникийн ажлын хэсгүүд байгуулахаа мэдэгджээ. Шүүхийн шийдвэр хараахан бүрэн хэрэгжээгүй байгаа ч энэ нь хариуцлага тооцож, бодит өөрчлөлт авчирахад чиглэсэн эхний чухал алхам болсон. Дэлхий даяарх дэмжигчдийн хамтын дуу хоолой, эв санааны нэгдэл энэхүү ахиц дэвшилд хүрэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан юм.



25 ЖИЛ
ЭРХИЙНХЭЭ ТӨЛӨӨ БИЧИЦГЭЭЭЕ
ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ

АЯАЧИ ХАММАМИ

ТУНИС



ҮНЭНИЙГ ХЭЛСНИЙХЭЭ ТӨЛӨӨ ХОРИГДОВ

АЯАЧИ ХАММАМИ

ТУНИС



Аяачи Хаммами бол Тунисын хүний эрхийн хуульч, хүний хань, аав, өвөө хүн юм. Тэрээр шударга бус явдлын хохирогчдыг өмгөөлж, хүний эрх болон шүүхийн хараат бус байдлын төлөө дуу хоолойгоо өргөсөөр иржээ. Найз нөхөд нь түүнийг эрч хүчтэй, шударга ёсны төлөө тууштай тэмцэгч хэмээн тодорхойлдог.

2021 онд Ерөнхийлөгч Кайс Саид эрх мэдлээ төвлөрүүлснээс хойш Аяачи Тунис дахь дарангуйллын шинжтэй бодлого, хүний эрхийн зөрчлийг ил тод шүүмжилж ирсэн. Тэрээр үзэл бодлоо тайван замаар илэрхийлсний төлөө хавчлагад өртсөн хуульчид, шүүгчид, сэтгүүлчид болон сөрөг хүчний төлөөлөгчдийг өмгөөлж байв.

Сөрөг хүчний улс төрчдийг хамарсан “Хуйвалдааны хэрэг”-т холбогдсон хүмүүсийг өмгөөлсний дараа Аяачи өөрөө терроризмтой холбоотой хэрэгт буруутгагджээ. 2025 оны дөрөвдүгээр сард шударга бус шүүх хурлын дараа түүнд найман жилийн хорих ял оноосон бөгөөд давж заалдах шатны шүүхээс таван жил болгон бууруулсан байна. Тэрээр өөрийн үндэслэлгүй хоригдож буйг эсэргүүцэн 45 хоног өлсгөлөн зарлажээ.

Аяачи Хаммамигийн хэрэг нь Тунисын эрх баригчид эрүүгийн шүүх тогтолцоог ашиглан шүүмжлэгчид болон хүний эрхийн өмгөөлөгчдийг хавчин шахаж буйг харуулж байна. Аяачи хоригдож байгаа ч, өөрийн эр зориг, шударга ёсны төлөөх тууштай байдлаараа олон хүнд урам зориг өгсөөр байна.

Тайван замаар хүний эрхийг хамгаалж, өмгөөллийн үйл ажиллагаа явуулсныхаа төлөө хоригдсон Аяачи Хаммамиг нэн даруй, ямар ч болзолгүйгээр суллахыг шаардаарай.

ТУНИС УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИД ЗАХИДАЛ БИЧЭЭРЭЙ

Аяачи Хаммамиг хүний эрхээ тайван замаар эдэлж, хүний эрх хамгаалагч, өмгөөлөгчийнхөө хувьд мэргэжлийн ажил үүргээ гүйцэтгэснийх нь төлөө хорьж байгаа тул түүнийг нэн даруй, ямар нэгэн болзолгүйгээр суллахыг шаардаарай!

ADDRESS: President of the Republic of Tunisia
Presidency of the Republic of Tunisia
Carthage Presidential Palace
Route de La Goulette
Tunis
TUNISIA

Letters and postcards can also be sent to embassies and consulates in your own country.

SALUTATION: Your Excellency

X: @TnPresidency
FACEBOOK: www.facebook.com/Presidence.tn
HASHTAGS: #FreeAyachiHammami, #Tunisia, #W4R26

УРЛАГИЙН БҮТЭЭЛ ТУУРВИЖ, ИТГЭЛ НАЙДВАРЫН ЗУРВАС ИЛГЭЭН АЯАЧИД ЭВ САНААНЫ ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭЭРЭЙ

Аяачи Хаммамид дэмжиж буйгаа илэрхийлсэн захидал, зурвас илгээх, эсвэл шударга ёсны төлөө тэмцэж буй, хайртай хүмүүстэйгээ цагийг өнгөрүүлж буй, нохойгоо салхилуулж, одот тэнгэр ширтэж буйгаар нь дүрслэн зураарай. Мөн түүнд хорих ангид унших франц эсвэл араб хэл дээрх ном санал болгож болно.

ADDRESS: Ayachi Hammami
29 Rue du 2 Mars 1934
2013 Ben Arous
TUNISIA

FACEBOOK: www.facebook.com/ayachi.hammami1
INSTAGRAM: free_ayachi
WEB: freeayachi.net



25 ЖИЛ
ЭРХИЙНХЭЭ ТӨЛӨӨ БИЧИЦГЭЭЭЭ
ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ

ДАРЬЯ ЕГЕРЕВА

ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС



НУТГИЙН ИРГЭДИЙНХЭЭ ЭРХИЙГ ХАМГААЛСНЫХАА ТӨЛӨӨ ШИЙТГҮҮЛЭВ

ДАРЬЯ ЕГЕРЕВА

ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС



Дарья Егерева бол Сибирийн Селкүп уугуул үндэстний төлөөлөл, багш мэргэжилтэй, уугуул иргэдийн эрх, байгаль орчин, уур амьсгалын шударга ёсны төлөө олон жил тэмцэж ирсэн идэвхтэн юм. Тэрээр тайгын байгальд гэр бүлийнхэнтэйгээ өсөж, байгаль дэлхий, нутгийнхаа соёл, иргэдтэй салшгүй холбоотой болсон нэгэн. Найз нөхөд нь түүнийг элдэг, халуун дулаан сэтгэлтэй, энэрэнгүй хүн хэмээн тодорхойлдог.

Гэвч өнөөдөр Дарья хүний эрхийг тайван замаар хамгаалж, дуу хоолойгоо өргөснийхөө төлөө 20 хүртэлх жилийн хорих ял шийтгүүлэх эрсдэлтэй тулгараад байна. 2025 оны арванхоёрдугаар сард ОХУ-ын эрх баригчид түүнийг баривчилж, уугуул иргэдийн эрхийг хамгаалах сүлжээг нь «террорист» байгууллага хэмээн буруутгажээ.

ОХУ-ын эрх баригчид «экстремизм», «терроризм» гэх нэр томьёог ашиглан хүний эрхийн төлөө тэмцэгчдийн дуу хоолойг хааж, иргэний нийгмийн орон зайг хумьж байна. Гэсэн хэдий ч Дарья дарамт шахалтад бууж өгөлгүй, уугуул иргэдийнхээ эрх, байгаль орчин, соёлын өвийг хамгаалах итгэл үнэмшилдээ үнэнч хэвээр байна.

Дарья Егереваг нэн даруй, ямар нэгэн болзолгүйгээр суллаж, ОХУ даяар эрхээ эдэлж буй уугуул иргэдийн эрхийн төлөө тэмцэгчдийг хавчин гадуурхаж, хэлмэгдүүлж буй явдлыг зогсоохыг шаардаарай.

ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН МӨРДӨН БАЙЦААХ ХОРООНЫ ДАРГАД ЗАХИДАЛ БИЧЭЭРЭЙ

Дарья Егереваг нэн даруй, ямар нэгэн болзолгүйгээр суллаж, ОХУ даяар уугуул иргэдийн эрхийн төлөө тэмцэж буй идэвхтнүүдийг хавчин гадуурхаж, хэлмэгдүүлж буй явдлыг таслан зогсоохыг шаардаарай!

ADDRESS: Head of the Investigative Committee of the Russian Federation
Investigative Committee of the Russian Federation
2 Tehnicheskiy Pereulok
105005 Moscow
RUSSIAN FEDERATION

SALUTATION: Dear Head of the Investigative Committee of the Russian Federation

SOCIAL MEDIA: Help amplify the message by tagging Russian embassies and consulates in your country via social media.

HASHTAGS: #FreeDariaEgereva, #ProtectIndigenousRights, #W4R26

ДАРЬЯАД ИТГЭЛ НАЙДВАР, ЭВ САНААНЫ ДЭМЖЛЭГИЙН ЗУРВАС ИЛГЭЭГЭЭРЭЙ

Зурвасаа орос хэлээр бичиж, илгээнэ үү.

Загвар зурвас:

Дорогая Дарья, мы узнали вашу историю и очень вдохновились вашей работой. Леса, реки и вся наша природа должны быть защищены. С приветом и солидарностью

ADDRESS: Egereva Daria Anatolyevna, 1977
FKU SIZO-6 92
Shosseynaya Street
109383 Moscow
RUSSIAN FEDERATION
(Including Daria's full name and year of birth is essential.)

25 ЖИЛ
ЭРХИЙНХЭЭ ТӨЛӨӨ БИЧИЦГЭЭЭЕ
ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ

ХАМФРИ ПОЛЕПОЛЕ

ТАНЗАНИ



ЗАСГИЙН ГАЗРЫГ ШҮҮМЖИЛСНИЙХЭЭ ТӨЛӨӨ ДИПЛОМАТЧ АСАН СУРАГГҮЙ АЛГА БОЛОВ

ХАМФРИ ПОЛЕПОЛЕ

ТАНЗАНИ



2025 оны аравдугаар сарын 6-нд Танзани улсын Засгийн газрыг шүүмжилж ирсэн дипломатч асан Хамфри Полеполег Дар-эс-Салам хот дахь гэрээс нь төрийн аюулгүй байдлын албаны нэрээ нууцалсан ажилтнууд хүчээр авч явсан гэх мэдээлэл байна. Гэр бүлийнхэн нь түүний гэрийнх нь хаалга эвдэрсэн, хэргийн газарт цусны ул мөр байхыг олжээ.

Түүнээс хойш гэр бүл, найз нөхөд нь түүнтэй холбоо барьж чадаагүй бөгөөд хаана байгаа нь тодорхойгүй хэвээр байна. Өндөр настай ээж нь хүүгээ эрэн хайж, "Хамфри минь, чи хаана байна вэ?" хэмээн уйлан дуудах болжээ.

Хамфри Засгийн газрын иргэний нийгмийн орон зайг хумих бодлого, хүний эрхийн зөрчил, улс төрийн сөрөг хүчнийг хавчин шахаж буй үйлдлийг тууштай шүүмжилж ирсэн тул ийнхүү онилогдсон гэж үзэж байна.

Тэрээр бусдад туслахыг эрхэмлэдэг, нийгмийн идэвхтэй нэгэн бөгөөд асрамжийн газруудаар зочилж, залуучуудад улс төрийн оролцооны талаар сургалт, семинар зохион байгуулдаг байжээ. Өдгөө гэр бүл, тэр дундаа өндөр настай ээж нь, Файтер хэмээх нохой нь түүнийг үгүйлэн хүлээсээр байна. Хамфри гэр бүлтэйгээ хамт, эрх чөлөөтэй байх ёстой.

Хүнийг хүчээр сураггүй болгох нь олон улсын эрх зүйгээр хориглосон ноцтой зөрчил юм.

Танзани улсын эрх баригчдаас Хамфригийн хаана байгааг нь нэн даруй ил тод мэдээлж, амь нас, аюулгүй байдлыг нь хамгаалахыг шаардаарай!

ТАНЗАНИ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИД ЗАХИДАЛ БИЧЭЭРЭЙ

Хамфри Полеполе одоо хаана байгааг нэн даруй ил тод мэдээлж, хэрэв цагдан хоригдож байгаа бол түүнийг нэн даруй суллахыг холбогдох байгууллагад үүрэг болгохыг шаардаарай!

ADDRESS: President of Tanzania
Office of the President
PO box 1102
1 Julius Nyerere Road Chamwino
40400 Dodoma
TANZANIA

SALUTATION: Dear President

SOCIAL MEDIA: cs@gov.go.tz
X: @SuluhuSamia
HASHTAGS: #WhereIsHumphreyPolepole, #FreeHumphreyPolepole, #JusticeForPolepole, #W4R26

ХАМФРИЙН ГЭР БҮЛД ЭВ САНААНЫ НЭГДЛЭЭ ИЛЭРХИЙЛЭЭРЭЙ

Хамфриг гэр бүлдээ эсэн мэнд эргэн ирээсэй хэмээн хүсэж буйгаа илэрхийлсэн зурвас илгээгээрэй. Мөн Хамфрийн хэлэх дуртай байсан Че Геварагийн "Ялалт байгуулах хүртэл тэмцлээ үргэлжлүүлэх ёстой" гэсэн эшлэлийг ашиглаж болно.

ADDRESS: Humphrey Polepole's family
c/o Amnesty International
East Africa Regional Office
197 Lenana Place, Lenana Road
PO box 1527-00606
Nairobi
KENYA

HASHTAGS: #WeStandWithHumphrey, #SolidarityForPolepole, #StandStrongPolepole, #YouAreNotAloneHumphrey, #W4R26

25 ЖИЛ
ЭРХИЙНХЭЭ ТӨЛӨӨ БИЧИЦГЭЭЭ
ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ

ИМААН МАЗАРИ-ХАЗИР БОЛОН ХАДИ АЛИ ЧАТТХА

ПАКИСТАН



ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛСНЫХАА ТӨЛӨӨ ХОРИГДСОН ГЭР БҮЛ

ИМААН МАЗАРИ-ХАЗИР БОЛОН ХАДИ АЛИ ЧАТТХА

ПАКИСТАН



Имаан Мазари-Хазир (баруун талд) болон Хади Али Чаттха (зүүн талд) нар хүний эрхийн чиглэлээр мэргэшсэн хуульч эхнэр нөхөр юм. Тэд нэгэн хүний эрхийг хамгаалах хэрэг дээр хамтран ажиллах үеэрээ танилцжээ. Ажлын бус цагаар найз нөхөдтэйгөө уулзаж, хамтдаа хооллох дуртай.

Тэд төр эрх мэдлээ урвуулан ашигласны улмаас хохирсон хүмүүсийн эрхийг хамгаалахад амьдралаа зориулсан бөгөөд дарамт шахалт, заналхийлэлд бууж өгөлгүй, үйл ажиллагаагаа тууштай үргэлжлүүлсээр ирсэн юм.

Имаан: "Заналхийллээс болж би хүний эрхийн төлөөх үйл ажиллагаагаа зогсоох талаар хэзээ ч бодож байгаагүй. Үргэлж аюулаас болгоомжилж явах нь зорьж буй үйл хэрэгтээ төвлөрөхөд саад болж, эцэст нь эсэргүүцэгчдийн хүссэн үр дүнд хүргэнэ" хэмээн хэлж байжээ.

Гэвч 2026 оны нэгдүгээр сарын 24-нд Пакистаны армийг шүүмжилж, Балоч болон Паштун үндэстний идэвхтнүүдийг дэмжсэн байр суурια нийгмийн сүлжээгээр илэрхийлснийх нь төлөө тэдэнд олон жилийн хорих ял оноожээ. Энэ нь шүүхийн тогтолцоог ашиглан үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хязгаарлаж, эрх баригчдыг шүүмжилсэн дуу хоолойг нухчин дарж буй явдлын нэг жишээ юм.

Өдгөө Имаан, Хади хоёр бие биеэсээ тусгаарлагдан хоригдож байна. Тэд хүний эрхийн төлөөх ажлаа үргэлжлүүлж, гэр бүлээрээ хамт байх ёстой.

Имаан Мазари-Хазир болон Хади Али Чаттха нарыг нэн даруй, ямар нэгэн болзолгүйгээр суллаж, тэдэнд оноосон ялыг хүчингүй болгохыг Пакистаны эрх баригчдаас шаардаарай!

ПАКИСТАН УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДАД ЗАХИДАЛ БИЧЭЭРЭЙ

Имаан Мазари-Хазир, Хади Али Чаттха нарыг нэн даруй, ямар нэгэн болзолгүйгээр суллаж, тэдэнд оноосон ялыг хүчингүй болгон, холбогдох хэргүүдийг хэрэгсэхгүй болгохыг шаардаарай!

ADDRESS: Prime Minister of Pakistan
Prime Minister's Office
Constitution Avenue
Sector G-5/2
Islamabad 44010
PAKISTAN

SALUTATION: Honourable Prime Minister

NOTE: Please do not use Amnesty International branding on your letters or envelopes

E-MAIL: info@pmo.gov.pk
X: @ThePMOPAK, @CMShehbaz
HASHTAGS: #ReleaseImaanAndHadi, #W4R26

ИМААН, ХАДИ НАРТАЙ ХАМТ БАЙГААГАА ИЛЭРХИЙЛЭЭРЭЙ

Имаан, Хади нарт урам зориг, итгэл найдварын зурвас илгээж, мөн тэдний үйл хэргийн талаар шүлэг, зураг, гар зургаар эв санааны нэгдлээ илэрхийлээрэй.

ADDRESS: Imaan Mazari-Hazir and Hadi Ali Chattha
c/o Amnesty International South Asia
23/2 Horton Place
Colombo 7, 00700
SRI LANKA

X: @ImaanZHazir, @AdvHadiali
FACEBOOK: www.facebook.com/hadi.dushkara, www.facebook.com/imaan.mazari
HASHTAGS: #ReleaseImaanAndHadi, #W4R26

25 ЖИЛ
ЭРХИЙНХЭЭ ТӨЛӨӨ БИЧИЦГЭЭЭЕ

ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ

МАРВА АРАФА

ЕГИПЕТ



ХОРИГДЛУУДЫН АР ГЭРТ ТУСАЛСНЫХАА ТӨЛӨӨ ХОРИГДОВ

МАРВА АРАФА

ЕГИПЕТ



Марва Арафа бол 33 настай, Египетийн хүний эрхийн идэвхтэн юм. Тэрбээр улс төрийн хоригдлууд болон тэдэнтэй хамт хоригдож буй хүүхдүүдийн эрхийг хамгаалж, ар гэрийнхэнд нь дэмжлэг үзүүлж иржээ. Гэвч 2020 оны дөрөвдүгээр сард Марваг дөнгөж хоёрхон настай охиных нь нүдэн дээр баривчилсан юм. Өдгөө найман нас хүрсэн охин нь эхийгээ маш их үгүйлж байна.

Марва хоригдлуудын ар гэрийнхэнд шоронгийн уулзалтын зардлаа төлөхөд нь тусалж, хоригдож буй хүүхдүүдийн эсрэг хүчирхийллийг эсэргүүцэн тэмцсэнийхээ төлөө шийтгүүлжээ. Баривчлагдсаныхаа дараа хоёр долоо хоногийн турш хаана байгаа нь тодорхойгүй байсан бөгөөд улмаар "терроризмыг дэмжсэн" гэх үндэслэлээр хэрэгт татагдсан байна. Тэрээр бүх насаар нь хорих ял оноож болзошгүй хэрэгт буруутгагдан, шударгаар шүүлгэх эрх нь зөрчигдөх эрсдэлтэй байна.

Хорих ангид байх хугацаанд Марвагийн эрүүл мэнд эрс муудсан ч шаардлагатай эмнэлгийн тусламж авч чадаагүй байна. Түүний хэрэг терроризмтой тэмцэх тухай хууль тогтоомжийг ашиглан хүний эрх хамгаалагчид болон эрх баригчдыг шүүмжилсэн хүмүүсийг хавчин гадуурхаж буй явдлыг харуулж байна. Гэсэн ч Марва суллагдана гэдэг итгэл найдвараа алдалгүй, охинтойгоо дахин уулзах өдрийг хүлээсээр байна.

Марва Арафаг нэн даруй, ямар нэгэн болзолгүйгээр суллахыг Египетийн эрх баригчдаас шаардаарай!

Зөвхөн хүний эрхээ эдэлснийхээ төлөө хоригдож байгаа Марва Арафаг нэн даруй, ямар нэгэн болзолгүйгээр суллаж, түүнд холбогдох бүх хэргийг хэрэгсэхгүй болгохыг шаардаарай!

ЕГИПЕТ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИД ЗАХИДАЛ БИЧЭЭРЭЙ

Эрхээ эдэлснийхээ төлөө хоригдож байгаа Марва Арафаг нэн даруй, ямар нэгэн болзолгүйгээр суллаж, түүнд холбогдох бүх хэргийг хэрэгсэхгүй болгохыг шаардаарай.

ADDRESS: President of Egypt
Office of the President
Al-Ittihadiya Palace
Al Nadi, El-Montaza, Heliopolis
Cairo Governorate 4460210
EGYPT

You can also send your appeals to the Egyptian embassy or diplomatic mission in your country.

SALUTATION: Your Excellency

EMAIL: p.spokesman@op.gov.eg
X: @AlsisiOfficial
FACEBOOK: www.facebook.com/AlSisiofficial
HASHTAGS: #FreeMarwaArafa, #Egypt, #W4R26

МАРВАД ИТГЭЛ НАЙДВАР, ЭВ САНААНЫ ДЭМЖЛЭГЭЭ ИЛЭРХИЙЛЭЭРЭЙ.

Марваг суллагдаж, охин, ээжтэйгээ эргэн уулзан, эрх чөлөөтэй амьдарч буйгаар нь дүрслэн зураарай.

Эв санааны нэгдлээ илэрхийлсэн захидал, ил захидлаа өөрийн орны Эмнести Интернэшнлийн салбарт, эсвэл салбаргүй бол дараах хаягаар илгээнэ үү:

ADDRESS: Marwa Arafa
c/o Amnesty International Secretariat
1 Easton Street
London WC1X 0DW
UNITED KINGDOM

FACEBOOK: www.facebook.com/FreeMarwaArafa
HASHTAGS: #FreeMarwaArafa, #Egypt, #W4R26



25 ЖИЛ
ЭРХИЙНХЭЭ ТӨЛӨӨ БИЧИЦГЭЭЕ
ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ

ОВЕН ЧОВ

ХОНКОНГ

АРДЧИЛЛЫГ ХАМГААЛЖ ТЭМЦСЭНИЙХЭЭ ТӨЛӨӨ ХОРИГДОВ

ОВЕН ЧОВ

ХОНКОНГ



Овен Чов бол сувилагч мэргэжилтэй, Түвдийн буддын шашин шүтдэг, нохой тэжээхийг хүсдэг залуу юм. Найз нөхөд нь түүнийг адал явдал, философид дуртай нэгэн хэмээн тодорхойлдог.

Тэрбээр дөнгөж 15 настайдаа ардчиллыг дэмжсэн анхны жагсаалдаа оролцож байжээ. Түүнээс хойш нийгмийн эмзэг бүлгийнхэнд тусалж, илүү шударга нийгэм байгуулахын төлөө тууштай тэмцсээр ирсэн. Гэвч Хонконгт үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх нь улам бүр эрсдэлтэй болж байв.

2020 онд Бээжингээс Хонконгт үндэсний аюулгүй байдлыг хамгаалах тухай хатуу чанга хуулийг хэрэгжүүлж эхэлсэн. Үүний дараа улс төрийн сөрөг хүчний үйл ажиллагаа хумигдаж, хараат бус хэвлэл мэдээллийн байгууллагууд үйл ажиллагаагаа зогсоон, иргэний нийгмийн олон байгууллага хаалгаа барихад хүрчээ.

Ийм нөхцөлд ч Овен 23 настайдаа бүх нийтийн сонгуульд нэр дэвшигчдийг тодруулах урьдчилсан сонгуульд нэр дэвшсэн юм. Гэвч эрх баригчид түүнийг болон бусад 46 оролцогчийг "төрийн эрх мэдлийг хорлон сүйтгэх" хэрэгт сэжиглэн буруутгажээ.

Овен 2021 онд баривчлагдаж, 2024 онд 12 жилийн хорих ял сонссон. Тэрбээр 2032 он хүртэл хоригдож болзошгүй бөгөөд сүүлийн гурван жилийн турш ганцаарчлан хоригдож байна.

Овены түүх Хонконгт өрнөж буй олон ижил түүхийн нэг юм. Нээлттэй нийгэм, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээрээ алдартай байсан Хонконгт өнөөдөр иргэд үзэл бодлоо илэрхийлэхээс эмээх нөхцөл байдал үүсээд байна.

Овен Човыг нэн даруй, ямар нэгэн болзолгүйгээр суллахыг Хонконгийн эрх баригчдаас шаардаарай!

ХОНКОНГИЙН ЗАСАГ ЗАХИРГААНЫ ОНЦГОЙ БҮСИЙН ДАРГАД ЗАХИДАЛ БИЧЭЭРЭЙ

Овен Човыг нэн даруй, ямар нэгэн болзолгүйгээр суллахыг Хонконгийн эрх баригчдаас шаардаарай.

ADDRESS: Chief Executive's Office
Tamar
HONG KONG

SALUTATION: Dear Chief Executive

EMAIL: ceo@ceo.gov.hk,
enquiry@1835500.gov.hk

FACEBOOK: www.facebook.com/johnleekachiu
李家超 John KC Lee

HASHTAGS: #FreeOwenChow, #W4R26

ОВЕН ЧОВЫГ ДЭМЖИЖ БАЙГААГАА ИЛЭРХИЙЛЭЭРЭЙ

Овенд ганцаараа биш гэдгийг нь мэдрүүлэх бүтээлч, урам зориг өгөх зурвас илгээгээрэй. Өөрийн дуртай философийн эшлэл, аяллын дурсамж, байгалийн зураг эсвэл нохойн зураг хуваалцаж болно.

ADDRESS: Owen Chow
c/o Amnesty International Secretariat
1 Easton Street
London WC1X 0DW
UNITED KINGDOM

25 ЖИЛ
ЭРХИЙНХЭЭ ТӨЛӨӨ БИЧИЦГЭЭЕ
ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ

РОКИАТУ ДУМБИЯ

МАЛИ



ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛСНИЙХЭЭ ТӨЛӨӨ ХОРИГДСОН ТІКТОК-ИЙН НӨЛӨӨЛӨГЧ, ИДЭВХТЭН

РОКИАТУ ДУМБИЯ

МАЛИ



Рокиату Думбия бол бизнес эрхлэгч, хүний эрхийн идэвхтэн, TikTok-ийн нөлөөлөгч юм. Тэрбээр 175,000 дагагчтай хуудсаараа дамжуулан иргэдийн өдөр тутмын бэрхшээл, хүнсний үнийн өсөлтийг хөндөн, эмэгтэйчүүд, гэр бүлүүдийг дэмжих олон нийтийн үйл ажиллагаа явуулж иржээ.

2023 оны гуравдугаар сард TikTok-оор шууд дамжуулалт хийх үеэрээ амьжиргааны өртгийн өсөлт болон цэргийн эрх баригчдыг шүүмжилснийх нь дараа түүнийг баривчилж, хэд хэдэн хэрэгт буруутгасан байна. Улмаар 2026 оны наймдугаар сард "төрийн нэр хүндийг гутаасан", "гэмт хэргийн бүлэглэл байгуулсан" гэх үндэслэлээр 10 жилийн хорих ял оноож, долоон жилийг нь биечлэн эдлүүлэхээр шийдвэрлэжээ.

Түүний хэрэг нь Мали улсад эрх баригчдыг шүүмжилсэн хүмүүсийг эрүүгийн хэрэгт татах замаар үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хязгаарлаж буйг харуулж байна. Ялангуяа олон нийтийн өмнө дуу хоолойгоо өргөсөн эмэгтэйчүүд цахим дарамт, ялгаварлан гадуурхалт, хэлмэгдүүлэлтэд өртөх эрсдэлтэйг онцолж байна.

Рокиату Думбияг нэн даруй, ямар нэгэн болзолгүйгээр суллахыг Мали улсын эрх баригчдаас шаардаарай!

МАЛИ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙН САЙДАД ЗАХИДАЛ БИЧЭЭРЭЙ

Рокиатуг нэн даруй, ямар нэгэн болзолгүйгээр суллахыг шаардаарай.

ADDRESS:
Minister of Justice and Human Rights Ministry
of Justice and Human Rights
Cité Administrative
Bâtiment 12, 3e étage
BP 97
Bamako
MALI

SALUTATION: Dear Minister of Justice

NOTE: Please do not use Amnesty International branding on your letters or envelopes.

EMAIL: mkassogue@justice.gouv.ml
X: @Ministere_Mali, @Ministreka
FACEBOOK: www.facebook.com/JusticeMali.Gouv
HASHTAGS: #FreeRosePoivron, #FreeRokiatou, #W4R26

РОКИАТУД ЭВ САНААНЫ НЭГДЛЭЭ ИЛЭРХИЙЛЭЭРЭЙ.

Түүний зоригтой тууштай байдал олон хүнд урам зориг өгч буйг нь сануулж, сэтгэлийн дэм өгөөрэй.

ADDRESS:
Rokiatou Doumbia
c/o Amnesty International West &
Central Africa Regional Office
Point E, Rue 34
Immeuble Malaado Plaza, 6th Floor
PO box 47582 Liberté
Dakar
SENEGAL

TIKTOK: @rokiatoudoumbia1
HASHTAGS: #FreeRosePoivron, #FreeRokiatou, #W4R26

25 ЖИЛ
ЭРХИЙНХЭЭ ТӨЛӨӨ БИЧИЦГЭЭЭЭ
ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ

РУТ ЛОПЕЗ

ЭЛЬ САЛЬВАДОР



ШУДАРГА ЁСНЫ ТӨЛӨӨ ДУУГАРЧ, ЭРХ ЧӨЛӨӨГӨӨ ХАСУУЛАВ

РҮТ ЛОПЕЗ

ЭЛЬ САЛЬВАДОР



Рүт Лопез бол хүний эрх хамгаалагч, хуульч бөгөөд авлига, хүний эрхийн зөрчлийн эсрэг олон жил тууштай тэмцэж ирсэн нэгэн юм. Тэрбээр амьдралаа шударга ёс, хууль дээдлэх ёсыг хамгаалахад зориулжээ. Мөн залуу хуульч, идэвхтнүүдэд мэдлэг, туршлагаа хуваалцахын зэрэгцээ чөлөөт цагаараа ном уншиж, цэцэрлэгээ арчлах дуртай.

2022 оноос хойш Эль Сальвадор улсад хэрэгжиж буй онц байдлын дэглэм нь эрх баригчдад хүний эрхийн идэвхтнүүд, шүүмжлэгчдийн дуу хоолойг хязгаарлах, хууль зүйн үндсэн баталгааг сулруулах өргөн эрх мэдэл олгожээ. Өнөөдөр хүний эрхийн зөрчлийн талаар тайван замаар үзэл бодлоо илэрхийлэх, хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаа явуулах нь эрх чөлөөгөө хасуулах эрсдэл дагуулах болжээ.

2025 оны тавдугаар сард Рүтийг гэрээс нь баривчилсан бөгөөд түүний хаана байгааг 40 гаруй цагийн турш мэдэх боломжгүй байв. Үүнээс хойш нэг жил өнгөрсөн ч түүнийг цагдан хорьсон хэвээр бөгөөд түүний шударгаар шүүлгэх, гэр бүл, өмгөөлөгчтэйгөө уулзах эрх нь зөрчигдөж байна.

Рүт Лопез нь тайван замаар эрхээ хэрэгжүүлснийхээ төлөө хоригдож буй үзэл санааны хоригдол юм.

Эль Сальвадор улсын эрх баригчдаас Рүт Лопезийг нэн даруй, ямар нэгэн болзолгүйгээр суллаж, түүнд холбогдох бүх хэргийг хэрэгсэхгүй болгохыг шаардаарай!

ЭЛЬ САЛЬВАДОР УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРТ ЗАХИДАЛ БИЧЭЭРЭЙ

Рүт Лопезийг нэн даруй, ямар нэгэн болзолгүйгээр суллаж, түүнд холбогдох бүх хэргийг хэрэгсэхгүй болгохыг Эль Сальвадор улсын эрх баригчдаас шаардаарай.

ADDRESS:
Attorney General of the
Republic of El Salvador
Attorney General's Office of
the Republic of El Salvador
Avenida El Boquerón y Calle Izalco
Urbanización Santa Elena
Distrito de Antiguo Cuscatlán
Municipio de La Libertad Este
La Libertad
EL SALVADOR

As letters in El Salvador are often censored, please also appeal to the Salvadoran embassy or diplomatic mission in your own country.

SALUTATION: Dear Attorney General

EMAIL: transparenciainstitucional@fgr.gob.sv
X: @FiscalGeneralSV
FACEBOOK: www.facebook.com/FGR.SV
HASHTAGS: #LibertadParaRuth, #W4R26

РҮТ ЛОПЕЗД ЭВ САНААНЫ НЭГДЛЭЭ ИЛЭРХИЙЛЭЭРЭЙ

Цахирмаа цэцгийн зураг болон дуртай номынхоо эшлэлийн хамт эв санааны нэгдлээ илэрхийлсэн захидал, мессеж илгээгээрэй.

ADDRESS:
Ruth López
c/o Amnistía Internacional Américas
Luz Saviñon 519
Col del Valle Nte
Benito Juárez
03103
Ciudad de México
MÉXICO

EMAIL: w4r26ruthlopez@gmail.com
X: @Cristosal
INSTAGRAM: Cristosal_ca, Cristosal_org
FACEBOOK: www.facebook.com/cristosalorg
(English content)

www.facebook.com/cristosalca
(Spanish content)

ЗАХИДАЛ БИЧИЖ ӨӨРЧЛӨЛТ ХИЙЦГЭЭЕ

25 ЖИЛ
ЭРХИЙНХЭЭ ТӨЛӨӨ БИЧИЦГЭЭЕ
ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ

Эмнести Интернэшнлийн "Эрхийнхээ төлөө бичицгээе" гарын авлагад тавтай морил. Эрхийнхээ төлөө бичицгээе 2026 аянд амжилттай оролцоход хэрэгтэй бүх мэдээллийг та эндээс олох боломжтой.

"Эрхийнхээ төлөө бичицгээе" аян хүмүүсийн амьдралыг өөрчилж чаддаг учраас таны үг бүр хүчтэй.

Энэ жилийн кампанит ажлын хүрээнд бид ердөө эрхээ эдэлснийхээ төлөө эсвэл хэн гэдгээсээ хамаарч эрх нь зөрчигдсөн хүмүүсийн төлөө захидал уриалга бичих юм. Бид хамтдаа шударга ёсыг шаардаж чадна.

Өөрчлөлтийн төлөө эрх баригчдад үнэний дуу хоолойг хүргэхийн тулд та энэ үйл ажиллагаанд нэгдэж байгаа учраас найз нөхөд, анги хамт олон, гэр бүлийн хамт, эсвэл ганцаараа оролцсон ч таны үг амьдралыг өөрчлөх хүчтэй.

ЯГ ОДОО БИДЭНТЭЙ НЭГДЭНЭ ҮҮ:

www.amnesty.org, www.amnesty.mn цахим хуудсаар зочилж, хүний эрхийн тухай мэдээллийг авч,

http://writeforrights2026.amnesty.mn/ цахим хуудсаар зочилж, өргөх бичигт гарын үсгээ зурж,

@AmnestyMongolia-ээр бидэнтэй хамт жиргэж, Amnesty International Mongolia хуудсанд нэгдэж, мэдээллийг бусадтайгаа хуваалцаарай.

Утас: 70004708
Цахим хаяг: members@amnesty.mn

